

БАТЛАВ: БОУАӨЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

МОНЗОРЕ ЭРДЭС ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

М.ЗЭСЭНБААТАР

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ
ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙ
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 4279077/

Хянасан:

ХУОБХГазрын Байгаль Орчны, Үнэлгээ Аудитын хэлтсийн мэргэжилтэн

З.Азжаргал

Боловсруулсан:

“Монзоре эрдэс” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн

Н. Энхзул

2024 он

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ
ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн нэр	3
Төслийн зорилго.....	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:.....	3
1.3 Төслийн хүчин чадал.....	3
1.4.1 Барилга байгууламж.....	3
1.4.2 Усан хангамж	3
1.4.3 Цахилгаан хангамж.....	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	4
2.1 Төслийн байршил.....	4
2.2 Төслийн газрын гадарга.....	5
2.3 Хөрсөн бүрхэвч	5
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	7
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	1
2	
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 9. ХОГ, ХЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	25
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	2
7	
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ	2
8	

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	3
Хүснэгт 2 Төсөл хэрэгжих талбайн солбилцол.....	4
Хүснэгт 3 Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	9

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ
ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4 БОМТ нийт зардал	13
Хүснэгт 5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний менежментийн төлөвлөгөө.....	14
Хүснэгт 6 Нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө.....	18
Хүснэгт 7 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ
ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	21
Хүснэгт 9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	23
Хүснэгт 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25
Хүснэгт 11 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	27
Хүснэгт 12 Оршин суугчдад тайлагнах.....	28

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг № 1. Төслийн талбайн байршил	4
Зураг № 2 Хөрсний хэв шинж.....	5
Зураг № 3. Ургамлын бүлгэмдэл.....	6

БҮЛЭГ1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

“Төмөр замыг түшиглэн нурмаг ачаа ачиж буулгах талбай байгуулах” төсөл

Төслийн зорилго

“Монзоре эрдэс” ХХК нь Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Монгол улсын экспортын нурмаг ачаа болох төмрийн хүдэр, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, улс орны эдийн засагт тодорхой хэмжээний хувь нэмэр оруулахад оршино.

Ковидын хүнд нөхцөлд БНХАУ-руу хийх экспорт чингэлэгт тээвэрт шилжсэнтэй холбоотойгоор МУ-ын тээвэрлэлтийн нөхцөл байдал хүндрэлтэй болсон. Иймд дотоодын орон нутгийн ачааны вагоноор Замын-Үүд өртөөнд нурмаг ачаа буулгаж, авто тээврээр БНХАУ-д экспорт хийх юм.

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Монзоре эрдэс” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	1911024053
Регистрийн дугаар	4279077
Хаяг	Дархан-Уул, Дархан, 6-р баг, 93 брак, 3,
Утас	99111152

1.3 Төслийн хүчин чадал

Замын Үүд өртөөний 19-р замын ачиж буулгах терминал нь 5 вагон буулгах хүчин чадал бүхий өндөрлөсөн замд нурмаг ачаа буулгаад авто тээврээр БНХАУ-руу экспортонд гаргах хүчин чадалтай байна.

1.4 Төслийн дэд бүтэц

1.4.1 Барилга байгууламж

Зориулалтын хашаа, Гаалийн ажилчдын байр, камержуулалт, авто пүү, зориулалтын орц гарц зэргийг төсөлд барихаар байна.

1.4.2 Усан хангамж

Төсөл хэрэгжүүлэгч нь унд ахуйн болон хэрэглээний цэвэр усаа цэвэр ус нийлүүлэгч баталгаат компанитай гэрээ байгуулан хангадаг.

1.4.3 Цахилгаан хангамж

Төсөл хэрэгжүүлэгч нь цахилгаан хангамжаа УБТЗ-аас гэрээгээр хангадаг.

1.4.4 Ариун цэврийн байгууламж

Төслийн талбай нь “УБТЗ” ХНН-ийн 19-р салбар төмөр замын дэргэд орших бөгөөд ажилчид тус байгууллагын ариун цэврийн байгууламжийг ашигладаг ба ариун цэврийн байгууламж нь “Монзоре эрдэс” ХХК-ийн ачилт буулгалтын талбайд хамаарахгүй болно.

**БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ
ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**

2.1 Төслийн байршил

Төсөл хэрэгжих талбайн Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 3-р багийн ТЗ ШАА гудамжинд байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 780 км, аймгийн төв Сайншандаас 230 км, МУ-ын хилээс 4.5 км-т УБТЗ-ын 19-р салбар төмөр зам дагуу байрлаж байна.

Доорх хүснэгтэд төсөл хэрэгжих талбайн координатыг харууллаа:

Хүснэгт 2 Төсөл хэрэгжих талбайн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	111°53'35.13"	43°43'50.63"
2	111°53'35.45"	43°43'50.79"
3	111°53'36.02"	43°43'50.56"
4	111°53'38.52"	43°43'50.38"
5	111°53'42.86"	43°43'47.33"
6	111°53'44.63"	43°43'45.96"
7	111°53'43.72"	43°43'45.41"
8	111°53'42.55"	43°43'44.71"
9	105 53 44.08	43 43 44.44
10	105 53 45.23	43 43 45.23
11	105 53 38.48	43 43 50.47
12	105 53 35.01	43 43 50.54
13	105 53 37.78	43 43 48.5
14	105 53 38.25	43 43 48.8
15	105 53 41.42	43 43 46.42
16	105 53 41.99	43 43 46.81
17	105 53 42.48	43 43 46.45
18	105 53 41.93	43 43 46.06



Таних тэмдэг

- Замын-Үүд
- Төслийн талбай


Зураг № 1. Төслийн талбайн байршил

2.2 Төслийн газрын гадарга

Төсөл хэрэгжих бүс нутаг болох Замын-Үүд сум нь монгол орны физик газарзүйн мужлалаар Говийн их мужийн Дорноговийн талархаг мужийн цөлөрхөг дэд хэсэгт багтана. Энэ бүс нь Монголын хээр, төв азийн цөлийн зааг дээр нэлээд эрт үүсэж бий болсон, биеэ даасан үүсэлтэй, зөвхөн уг бүсэд ургадаг зонхилочг ургамлуудтай байдгаараа онцлог бөгөөд тэр нь Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговийн нам өндөрлөг, Говь Алтайн нурууг хамаарна. Харин геотектоникийн мужлалаар Өмнөд говийн геосинклиналь атриат тогтолцооны Замын-Үүдийн хотгорт багтдаг.

2.3 Хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжих талбайд монгол орон газарзүйн байршлын хувьд Дорнод Сибирийн цэвдэгт тайгаас Төв Азийн хуурай цөлд шилжих завсрын нутгийг эзлэх тул байгалийн нөхцөлийн ялгаа маш эрс тэс, нөгөө талаар гадаргын төрх байдал жигд биш өндөр нам уул нуруу, хотос хонхор, ухаа гүвээ, хяр толгод, хөндий хоолой, нүд алдам тал газар хосолсон учраас хөрсөн бүрхэвчийн бүтэц, бүрэлдэхүүн ихээхэн ярвигтай, олон янзын өвөрмөц маягийн хөрс үүсэж, хөгжих нөхцөл бүрджээ.



Зураг № 2 Хөрсний хэв шинж


Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй хүрэн цайвар хүрэн, бор хүрэн, тал нам дор газартаа цайвар шаргал, хужирлаг өндөрлөг газартаа уулын хүрэн хүрэвтэр өнгийн хөрсүүд ялгагдана. Хүрэн цайвар болон бор хүрэн цайвар шаргал хөрс нь аллювиваль-нуурын гаралтай шавар, шавранцраас тогтоно.

2.4 Ургамлан бүрхэвч

Төсөл хэрэгжих бүс нутаг нь Ургамал газар зүйн мужлалаар Евро–Азийн хээрийн мужийн Умард говийн цөлийн хээрийн тойргийн Борхойн талын районд хамаарагдана.

Ургамалжилтын хувьд хялгана, ерхөг, таана, хазаар өвс, шарилж, ортууз, харганаас бүтсэн дэгнүүлт үетэнт, заримдаг сөөгөнцөр-дэгнүүлт үетэнт бүлгэмдэл голлох ба энэ нь тачир ургамалтай төдийгүй харьцангуй сийрэг юм. Хэмжилт хийхэд 1 м² талбайд 3 зүйлийн ургамал бүртгэгдсэн, нийт ургац 30-40%, дунджаар ургамал нөмрөг тачир сийрэг, голлон ургах хармаг дунджаар 50 см өндөртэй байхаас гадна хүчтэй салхины нөлөөгөөр энэ тэнд хармагийн бутанд хурж тогтсон довцог элс үүссэн байх нь элбэг. Загт элсэн хучаас бүхий хотгорт торлог, сухай, хармаг, алтан харгана, бор шаваг, бударгана, нохойн шибээ буюу хялганат хээрийн ургамалтай хил залган алаглан ургах боловч хоолой болон шалын элстэй төв хэсгээс жинхэнэ тал хүртлэх нарийн зурвас газраар толболсон өвөрмөц хэв шинжийг үүсгэн оршино. Гадаргын хувьд ухаа гүвээт тал, уулс хоорондын томоохон хотгор, хөндий хоолой энд хамрагдана.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ
ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг № 3. Ургамлын бүлгэмдэл

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 Дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-д нийцүүлэн “19-р замын ачиж буулгах терминал” төслийн зураг төсөл, хөрс, усны шинжилгээний дүн, ландшафт болон төсөл хэрэгжүүлэх газрын байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, сум орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг баримт бичгийг үндэслэн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, тусгай хамгаалалттай газар нутаг болон төсөл хэрэгжих орон нутгийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл зэргийг магадлан жагсаах арга буюу хяналтын хуудасны арга ашиглан тодорхойллоо. Мөн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн дүнгүүдийг тусгав. Байгаль орчны нарийвчилан үнэлгээний судалгаа, гол болон болзошгүй нөлөөллийг тогтоох, түүнд үнэлгээ өгөхөд ашигласан арга, загварчлал, тооцооллын үр дүнг тусгалаа. Үнэлгээний судалгааны явцад цуглуулсан мэдээ, мэдээлэл, хээрийн судалгааны явцад хийсэн хэмжилтийн эх сурвалжийг тодорхой бичихээс гадна, эх хувиар нь тайланд хавсаргаж, фото зураг, бичлэгээр баталгаажуулан тайланд тусгасан болно.

Нөлөөлөл 1. Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл:

- Автотээврийн хэрэгслээс ялгарах хорт хий
- Төмөр замыг засварлах үед үүсэх тоосжилт
- Галт тэрэг болон тоног төхөөрөмжийн дуу чимээ
- Тоос, тоосонцор нь тунадасжин бууж хөрс, гүний усанд орж тархах, бохирдуулах
- Тоосжилт ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх
- Нүүрс болон төмрийн хүдэр ачиж буулгахад үүсэх тоосжилт

Нөлөөлөл 2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл:

- Тээврийн хөдөлгөөнөөс хөрсний эвдрэл үүсгэх
- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадарга эвдэгдэх
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяаагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ
ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хөрсийг бохирдуулах

- Тоос хөрсөнд хуримдагдаж бохирдол үүсэх
- Нүүрс болон төмрийн хүдрийн овоолго үүсэх үед хөрсөн бүрхэвч антропоген нөлөөлөлд өртөх

Нөлөөлөл 3. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:

- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор ургамлан нөмрөг талхлагдах
- Тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт ургамлан нөмрөгт дам нөлөөлөл үзүүлэх
- Нүүрс ачиж, буулгах үед түүнд дарагдах
- Барилгын ажлын үед үүсэх барилгын хог хаягдалд ургамлан нөмрөг талхлагдах

Нөлөөлөл 4. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл:

- Газрын доорхи усны нөөц хомсдох,
- Орчны тоосжилт бууруулахад ус ашигласны улмаас усны нөөц хомсдох
- Гадаргын усны урсац, голдиролыг өөрчлөх
- Төслийн талбайн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хог хаягдлыг зайлуулаагүйн улмаас хог хаягдал гадаргын болон газрын доорх усыг бохирдуулах

Нөлөөлөл 5. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагаанд өртсөн талбайн ургамлан нөмрөг устах бөгөөд үүнийг даган бичил амьтад ч мөн амьдрах орчноосоо дайжна.
- Дуу чимээ, тоосны бохирдол, амьтны нүх, үүрэнд шууд нөлөөлснөөр амьдрах орчинд сөргөөр нөлөөлнө.
- Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох
- Төслийн үйл ажиллагаанаас бий болох хог хаягдлыг эмх замбараагүй хаяснаар амьтдын амьдрах орчин бохирдох, зарим зүйл амьтан хордох магадлалтай.
- Амьтдын амьдрах орчин хуваагдах

Нөлөөлөл 6. Дуу чимээний үзүүлэх нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагаа эхэлснээр үүсэх дуу чимээ нь ажилчдын эрүүлү мэндэд нөлөөлөх
- Нутгийн оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах
- Амьтдад ойр орчмоос дайжих

Магадлан жагсаах аргаар үнэлэх: Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм. Аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах үеийн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тодорхойлохын тулд магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ арга нь экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруулах замаар хэрэгждэг.

Магадлан жагсаах арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

“19-р замын ачиж буулгах терминал” төслийн үйл ажиллагааны явцад төсөл хэрэгжих орон нутгийн байгаль орчны төлөв байдал, биологийн олон янз байдал, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил, нутгийн иргэдийн эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар гүйцэтгэн доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 3 Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөх байдал			Хугацаа		Эргэлт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага	Дунд	Их
Байгалийн бүрэлдэхүүн хэсгийн өөрчлөлт											
1	Уур амьсгалын өөрчлөлт		x			x	x			x	
2	Усны чанар өөрчлөгдөх		x		x		x		x		
3	Гадаргын усны урсац өөрчлөгдөх		x		x		x		x		
4	Ургамлын экосистем өөрчлөгдөх	x				x	x			x	
5	Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх	x				x	x			x	

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ
ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

6	Геологийн тогтоц өөрчлөгдөх		x		x			x	x		
7	Зэрлэг амьтдын тархац нутаг өөрчлөгдөх		x		x			x	x		
Байгалийн нөөц ашиглалт											
8	Бэлчээр, тэжээлийн байдал		x			x		x	x		
9	Эрдэс түүхий эдийн нөөц /ус/	x				x		x		x	
9	Эрчим хүчний нөөц	x				x		x	x		
Байгаль орчны өөрчлөлт											
10	Ундны усны чанар, хэмжээ		x			x	x		x		
11	Урсгал усны нөөцийн горим		x		x			x	x		
12	Агаарын бохирдол	x				x	x				x
13	Хөрсний бохирдол	x				x	x			x	
14	Хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх	x				x	x			x	
15	Дуу чимээний нөлөөлөл	x				x		x			x
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
16	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x				x		x		x	
17	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	x				x		x	x		
18	Хүн амын орлого өөрчлөгдөх	x				x		x		x	
19	Хүн амын эрүүл мэнд, соёл	x				x		x		x	
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
20	Байгалийн дүр төрх өөрчлөгдөх	x				x		x			x
21	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x			x
22	Түүх соёлын дурсгалт зүйлс өөрчлөгдөх			x							
Нийгэм, эдийн засгийн асуудал											
23	Ядуурлыг бууруулахад дэмжих		x			x		x		x	
24	Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x	
25	Дүн	15	9		5	19	9	15	9	11	4

Шууд нөлөөлөлд: 15 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн шууд нөлөөлөлд ургамлан нөмрөг талхлагдах, агаарын болон хөрсний бохирдол, дуу чимээний нөлөөлөл, бэлчээр, тэжээлийн байдал, эрчим хүчний нөөц, хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх, ахуйн бохир уснаас хөрс, газрын доорх ус бохирдох, ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх, байгалийн дүр төрх өөрчлөгдөхтэй холбоотой юм. Эдгээр болзошгүй сөрөг нөлөөллийн ихэнх нь тодорхой хэмжээгээр байгаль орчны тэнцвэрт байдалд нөлөөлж байна. Төслийн үйл ажиллагаа эхэлснээр ажлын байр нэмэгдэх, орон нутгийн орлого нэмэгдэх, ажилгүйдэл буурах зэрэг эерэг нөлөөтэй байна.

Шууд бус нөлөөлөлд: 9 зүйлийн нөлөөлөл хамрагдаж байна. Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн шууд бус нөлөөлөлд гадаргын усны урсацын өөрчлөлт, гадаргын усны чанарын өөрчлөлт, геологийн тогтоцын өөрчлөлт, зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлт, зэрэг нөлөөлөл хамрагдаж байна.

Урт хугацааны нөлөөлөлд: 19 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн урт хугацааны нөлөөлд ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, уур амьсгалын өөрчлөлт, ундны усны чанарын өөрчлөлт, хорт бодис хүн амьтанд нөлөөлөх, дуу чимээний бохирдол, байгалийн дүр төрх өөрчлөгдөх зэрэг нөлөөлөл хамарч байна. Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс ихэнх нь урт хугацааны нөлөөлөлд хамаарч байна.

Буцаж нөлөөлөх нөлөөлөлд: 9 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн буцаж нөлөөлөх нөлөөлөлд ургамлан нөмрөг талхлагдах, агаарын болон хөрсний бохирдол, дуу чимээний нөлөөлөл, бэлчээр, тэжээлийн байдал, эрчим хүчний нөөц, хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх, ахуйн бохир уснаас хөрс, газрын доорх ус бохирдох зэрэг нөлөөлөл хамаарч байна.

Буцалтгүй нөлөөлөлд: 15 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн буцалтгүй нөлөөлөлд геологийн тогтоцын өөрчлөлт, зэрлэг амьтдын орон үайн өөрчлөлт, бэлчээр, тэжээлийн байдал, эрдэс түүхий эдийн нөөц /ус/, эрчим хүчний нөөц, урсгал усны нөөцийн горим, дуу чимээний нөлөөлөл зэрэг хамрагдаж байна. Харин орон нутгийн дэд бүтэц, ажлын байр нэмэгдэх, орон нутгийн хүн амын эрүүл мэнд, үйлчилгээнд туслах, ядуурлыг бууруулахад дэмжлэг болох гэсэн асуудлыг богино хугацааны эерэг нөлөөлөд хамрууллаа. **Хүчтэй нөлөөлөлд:** 4 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Үүнд агаарын бохирдол, дуу чимээний нөлөөлөл, байгалийн дүр төрх өөрчлөгдөх, ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэрэг нөлөөллүүд хамрагдана.

Дунд нөлөөлөлд: 11 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн буцаж нөлөөлөх нөлөөлөлд ургамлан нөмрөг талхлагдах, агаарын болон хөрсний

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ
ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

бохирдол, дуу чимээний нөлөөлөл, бэлчээр, тэжээлийн байдал, эрчим хүчний нөөц, хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх, ахуйн бохир уснаас хөрс, газрын доорх ус бохирдох зэрэг нөлөөлөл хамаарч байна.

Бага нөлөөлөлд: 9 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Гадаргын усны урсац өөрчлөгдөх, геологийн тогтоц, зэрлэг амьтдын тархац нутаг өөрчлөгдөх зэрэг нөлөөлөл хамрагдаж байна.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Дорноговь аймгийн Замын-үүд сумын нутагт оршин “Монзоре эрдэс” ХХК-ийн хэрэгжүүлж буй төмөр замын ачиж буулгах талбай төслийн үнэлгээний ажлын явцад үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Төслийн хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн бүтээн байгуулалт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр эвдрэлд орж сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн нь хөрсөн бүрхэвч юм. Сөрөг нөлөөллийн цар хүрээ багаас дунд зэрэг ба урьдчилан сэргийлэх болон бүтээн байгуулалтын дараа болон олборлолт дууссан хэсэгт нөхөн сэргээх талаар төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх тохиолдолд нөлөөллийн эрчим эрс буурах боломжтой.

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү тайлангийн 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) үндэслэн боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлж байх шаардлагатай. Үүнээс гадна тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ), түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ
ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

Хүснэгт 4 БОМТ нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Зардал (мян.төг)
	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	900,0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт төлөвлөгөө	480,0
3	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	900,0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	700,0
6	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	165,0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	855,0
	2024 оны нийт зардал	4.000.0

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт стандарт
Агаар орчин								
Нүүрс ачих, тээвэрлэх, буулгах үйл ажиллагааны явцад ажлын талбай дээр тоосжилт үүсэх, нийлүүлэгдэж түүхий эд болох нүүрснээс агаарт хийсч орчны бохирдол үүсгэх	Түр ба туслах замууд, барилгын ажлын идэвхтэй талбайд байнгын усалгаа хийх	Үйл ажиллагааны турш	-	Ү.А-ны зардлаар	-	Үйл ажиллагааны зардлаар	2024 он	Агаарын тухай хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688:2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004 Бензинхөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүнд машин механизм болон бусад тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс агаар бохирдох, мөн хүнд даацын автомашины хөдөлгөөнөөс агаарт тоосжилт үүсэх нөхцөл бүрдэх	Тээврийн хэрэгслүүдийг тогтмол үзлэг, оношлогоонд хамруулж, утаанд хяналт тавьж ажиллах, засвар үйлчилгээг тогтмол хийж байх Ажилчдад /маск, иж бүрэн хувцас, чихэвч, нүдний шил г.м/ хамгаалах хэрэгслээр хангах	Үйл ажиллагааны турш	-	Ү.А-ны зардлаар	-	500.0	2024 он	MNS 5013:2009: Бензин хөдөлгүүртэй автомашин-утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин-утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
Тоосжилт, хорт хий хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх		Үйл ажиллагааны турш	Тоо/ширхэг				2024 онд	MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага
ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ								
Газар ашиглалтын зөв зохистой ашиглаагүйгээс хөрс, ургамлан бүрхэвчийн талхлагдлыг нэмэгдүүлэх, бохирдуулах	Бүтээгдэхүүнийг зөвхөн зөвшөөрөгдсөн талбайд байршуулах	Төслийн талбайд	-	Ү.А-ны зардлаар		-	2024 он	Газрын тухай” хууль MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга “Газрын тухай” хууль
	Ачилт буулгалтын талбайн төлөвлөлтийг зөв зохион байгуулах, Ашиглаж байгаа газрын хэмжээгээр газрын төлбөрийг төлөх	Төслийн талбайд	-	Ү.а-ны зардлаар		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2024 он	
Усан орчин								

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн цаашдын үйл ажиллагааны явцад ажилтан, үйлчлүүлэгчдийн унд ахуй хэрэглээний усны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Эрүүл ахуйн шаардлага хангасан баталгаатай эх үүсвэрээс унд ахуйн усыг нийлүүлэх	Төсөл хэрэгжих талбайд	-	Ү.А-ны зардлаар		-	2024 он	MNS0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаарлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Хөрсөөр дамжин нефтийн бүтээгдэхүүн усанд нэвчих	Хөрсөн дээр нефтийн бүтээгдэхүүн асгаж гоожуулахгүй байх.	Төсөл хэрэгжих талбайд	-	+	-	-	2024 он	MNS5850:2008 хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт								900,000

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6 Нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт стандарт
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	Төслийн талбайн хашааг тойруулан 10 ширхэг мод тарих	Төслийн талбайд	10	ш	8,000	80,000	2024 онд	MNS6260:2020 Зүлэгжүүлэх талбай бэлтгэл үр тарих, арчлах Ургамал хамгааллын тухай хууль
Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аймаг орон нутгийн зааж өгсөн газар мод тарих	Замын-Үүд сумын нутагт	50	ш	8,000	400,000	2024 онд	Биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага. MNS5914:2008
Авто тээврийн хөдөлгөөн, барилга байгууламж байгуулах талбайгаас гадна орших ургамлыг талхагдалд оруулахгүй байх.	Зөвшөөрөгдсөн талбайд машин техник явуулах	Төслийн талбайд	Шаардлагатай талбайд	М³	-	Үйл ажиллагааны зардлаар	2024 онд	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, нэр томьёо, тодорхойлолт MNS5918:2022 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS 6253-2: 2011 Мод, сөөгний үр тарих. Техникийн шаардлага
Нийт						480.000		

БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал сая төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт стандарт
<p>Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.</p>							

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт стандарт
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Үйл ажиллагааны турш	-	Үйл ажиллагааны зардлаар	-	Өдөр бүр, тогтмол ажлын хугацаанд	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1, - MNS4968:2000. ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага - MNS4995:2000. ХААЭА.
	Гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	1	250.0	250.0	2024 онд	Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага MNS5010:2001. ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS5078:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй.
	Эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны турш	6	50.0	300.0	Жил бүр	Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага MNS5566:2005 Аж ахуй нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл
Аянга, цахилгаан-Ажлын байрны аюулгүй байдал, дэд бүтцийн барилга байгууламж эвдэрч сүйдэх, цахилгаан тасрах, хүний амь эрсдэх	Зураг төсөл стандартын дагуу аянга цахилгааны хамгаалалтыг байрлуулах	Төслийн талбайд	Төслийн талбайг бүхэлд нь хамрах хэмжээнд	50.0	50.0	Төслийнн туршид	

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Шороон шуурга-Үйлдвэрлэл зогсох, дэд бүтэц эвдрэх, хүний эрүүл мэнд муудах, хохирох, доголдол нуралт үүсэх	Төслийн эргэн тойрны хөрсний эвдрэлийг багасгах арга хэмжээ авч байх	Төслийн талбай болон түүний эргэн тойронд	-	-	-	Төслийн турш	
Газар хөдлөлт-Барилга байгууламж нурж, хүний амь нас эрсдэх, дэд бүтцийн байгууламж эвдрэх	Газар хөдлөлтийн үед хэрэгжүүлэх зөвлөгөө сургалт орох	Төслийн талбайд	-	-	-	Төслийн турш	
Нийт					900,000		

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 9. ХОГ, ХЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдалын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт стандарт
Ахуйн хог хаягдал	Ахуйн гаралтай хатуу хаягдлыг чанарын шаардлага хангахуйц түр хураан агуулах сав хэсэг бэлтгэх шаардлагатай.	Үйл ажиллагааны талбайд	-	Үйл ажиллагааны зардлаар	-	300.0	2024 онд	Хог хаягдлын тухай хууль, MNS6200:2010 Хаягдлын сангийн стандарт
Бүх төрлийн хог хаягдал	Хогийн савыг бат бөх зориулалтын битүү тагтай хийх	Төслийн талбайд	ш	50.0	8	400.0	2024 онд	
Нийт	700,000							

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Хөрс								
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	Төслийн талбайн нэг цэг сонгон хөрсний шинжилгэ хийлгэх.	2024 он	Жилд 1 удаа	80,000	160,000	Хөрсийг агрохими, хүнд мяталл, эрүүл ахуй, механик бүрэлдэхүүний шинжилгээг хийлгэнэ	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,
2	Хөрсний агрохимийн үзүүлэлт							
3	Хөрсний хүнд металлын үзүүлэлт							
4	Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт							
Усны шинжилгээ								
8	Усны ерөнхий үзүүлэлт	Усны үүсвэрээр эх	2024	Жилд 1 удаа	100.0	200.0	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ, хатуулаг	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт бохирдол)
9	Усны түвшин (газрын гадаргаас доош, м-ээр)	Унд ахуйн уснаас	Улиралд 1 удаа	Жилд 1 удаа	100.0	100.0		
					Нийт 855,000			

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 11 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаал	Тайлбар
			Сар 5	Сар 9	Сар 12		
1	2024 оны биелэлтийн тайланг тайлагнана.		11.01нд			Төслийн менежер	БОМТ-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх.
2	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	Үйл ажиллагааны зардлар	+	+	+	Менежер	
2	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх		+	+	+	Менежер	
3	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогмолжуулж илэрсэн зөрчилийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	100.0	+	+	+	Менежер	
4	Ажилчдыг шаардлагатай ажлын хувцасаар хангах	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	Менежер	
5	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа багаж хэрэгсэл хайрцагтай болох	65.0	+	+	+	Менежер	
6	БОУтухай хуулийн 9.9." Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх.	2,000,000				Захирал	Үйл ажиллагааны зардлаар
7	Нийт зардал						165,000

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТАЛБАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ**

Хүснэгт 12 Оршин суугчдад тайлагнах

№	БОМТ, БОХТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Дорноговь аймгийн Замын-Үүд сумын удирдлагуудад танилцуулах	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж бичвэр хэлбэрээр Замын үүд сумын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	2024 оны 11 сарын 1-ээс өмнө	Үйл ажиллагааны зардлаар	Менежер	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын засаг захиргаа
2	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Дорноговь аймгийн Замын-Үүд сумын иргэдэд танилцуулах	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Дорноговь аймгийн Замын-Үүд сумын иргэдэд танилцуулах	БОМТ-ний биелэлт	11 сарын 1 нээс өмнө	Үйл ажиллагааны зардлаар	Менежер	
3	2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлангийн хэрэгжилтийг батлуулах	Аймгийн БОАЖГ, БОУАӨЯ-аар хянуулах	БОМТ биелэлт	2024 оны 11 сарын 1-ээс өмнө	Үйл ажиллагааны зардлаар	Байгаль орчны мэргэжилтэн	ЕИС Цахим систем

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2663, факс: (02-522) 4-27-26
Цахим шуудан: Dgaboajg@do.mnc.gov.mn
Цахим хаяг: www.do.mine.gov.mn

2024.09.20 № 36

танай _____-ны № _____-т

Дүгнэх хуудас, чиглэл хүргүүлэх
тухай

Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах “Нүүрс ачих буулгах талбай”-н 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг **90.1 хувьтай** үнэлэн, дүгнэх хуудсыг хүргүүллээ.

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх цаашид анхаарах асуудлыг чиглэл болгон хүргүүлж байна. Үүнд:

1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа тоо баримттай, арга хэмжээ тус бүрт баримт, фото зургийг хавсаргаж, дэлгэрэнгүй тайланд тусгах;

2. Байгаль орчны хууль тогтоомжийн хүрээнд дотооддоо журмуудыг боловсруулах, хөгжүүлэх, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;

3. Ус ашиглах дүгнэлт гаргуулах, ус ашиглалтын тайланг тухайн оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор аймгийн Байгаль орчны газарт ирүүлэх;

4. Тоосжилт дарах сайн туршлага, дэвшилтэт арга хэмжээг судлах, турших, хэрэгжүүлэх;

5. Бохир ус хаях цэгийг стандартын дагуу тохижуулах, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол гүйцэтгэх;

6. Аюултай хог хаягдлыг түр хадгалах цэг байгуулж хадгалах, түр хадгалах талбайг хашаажуулах, тэмдэгжүүлэлт хийх;

7. Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад гэрээний үндсэн дээр шилжүүлэх, бүртгэл болон холбогдох баталгаажуулалтыг гүйцэтгэх;

8. Сумын засаг даргатай хог хаягдлын гэрээ байгуулж ажиллах

9.Ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, тарьсан модыг арчилж ургуулахад анхаарах;

10.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орон нутгийн иргэд, сумын удирдлагуудад танилцуулж байх зэрэг ажлуудыг авч хэрэгжүүлэхийг үүгээр мэдэгдье.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА



Н.ОТГОНБАЯР


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ “НҮҮРС АЧИХ
БУУЛГАХ ТАЛБАЙ”-Н 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ХУУДАС
Дугаар 2023/41


Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: Монзоре эрдэс ХХК
Төслийн байршил: Дорноговь аймаг, Замын-Үүд сум
Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 4279077
Огноо: 2024.09.18

№	Бүрэлдэхүүн хэсэг	Авбал зохих оноо	Нийт оноо	Дундаж	Үндэслэл шаардлага
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Агаар орчныг хамгаалах	25	109.5	21.9	
2	Орчны тохижилт, Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	30	142.7	28.54	
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15	72.7	14.54	
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	38.5	7.7	
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт	10	49.7	9.94	
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	22.9	4.58	
7	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	14.7	2.94	
8	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	-	-	-	-
	Эцсийн дүн: оноо/хувь	100	450.7	90.1	


Дүгнэлт: БОАЖСайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны А/618 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу “Монзоре эрдэс ХХК”-ийн Нүүрс ачих буулгах талбайн төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг **90.1** хувьтай дүгнэв.


ДУГНЭСЭН:

Комиссын дарга:  Аймгийн Байгаль орчны газрын дарга
Н.Отгонбаяр

Нарийн бичгийн дарга:  Аймгийн Байгаль орчны газрын Газар,
газрын хэвлий, нөхөн сэргээлт
хариуцсан мэргэжилтний үүргийг түр
орлон гүйцэтгэгч Ш.Амарбилэг

Гишүүд:

 Аймгийн Байгаль орчны газрын Усны
асуудал хариуцсан мэргэжилтэн
Ш.Амгалансайхан

 Аймгийн Байгаль орчны газрын
Байгаль орчны хяналтын улсын
байцаагч Э.Анхбаяр

Замын-Үүд сумын ЗДТГ-ын байгаль
орчин, аялал жуулчлалын асуудал
хариуцсан мэргэжилтэн Б.Наранчимэг

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

“Монзоре эрдэс” ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн *Н. Энхзул* Н.Энхзул

2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ “НҮҮРС АЧИХ БУУЛГАХ ТАЛБАЙ”-Н 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ХУУДАС**

Дугаар 2023/41


Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: Монзоре эрдэс ХХК
Төслийн байршил: Дорноговь аймаг, Замын-Үүд сум
Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 4279077
Огноо: 2024.09.18

№	Комиссын гишүүд Бүрэлдэхүүн хэсэг	Авбал зохих оноо	Н.Отгонбаяр	Ш.Амарбилэг	Э.Анхбаяр	Ш.Амгалансайхан	Б.Наранчимэг	Нийт оноо	Дундаж	Үндэслэл шаардлага
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Агаар орчныг хамгаалах	25	21	22	20	24.5	22	109.5	21.9	
2	Орчны тохижилт, Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	30	28	29	28	27.7	30	142.7	28.54	
3	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15	15	14	14	14.7	15	72.7	14.54	
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	9	7.5	9	5	8	38.5	7.7	
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт	10	10	10	10	9.7	10	49.7	9.94	
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	4	5	4	4.9	5	22.9	4.58	
7	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	4	3	3	4.7	0	14.7	2.94	
8	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	-	-	-	-	-	-	-	-	Төлөвлөгдөөгүй.
	Нийт	100	91	90.5	88	91.2	90	450.7	90.1	
	Эцсийн дүн /хувиар/	90.1	91	90.5	88	91.2	90	450.7	90.1	

Дүгнэлт: БОАЖСайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны А/618 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу "Монзоре эрдэс ХХК"-ийн Нүүрс ачих буулгах талбайн төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг **90.1** хувьтай дүгнэв.

ДҮГНЭСЭН:

Комиссын дарга:



Аймгийн Байгаль орчны газрын дарга Н.Отгонбаяр

Нарийн бичгийн дарга

Аймгийн Байгаль орчны газрын Газар, газрын хэвлий, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Амарбилэг

Гишүүд:

Аймгийн Байгаль орчны газрын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн Ш.Амгалансайхан

Аймгийн Байгаль орчны газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Э.Анхбаяр

Замын-Үүд сумын ЗДТГ-ын байгаль орчин, аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Наранчимэг

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

"Монзоре эрдэс" ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн *Н. Энхзул* Н.Энхзул

2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр



Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000900039037

Системийн огноо/System Date:2024.10.16 16:46:30

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5070995199	МОНЗОРЕ ЭРДЭС	2,000,000.00 MNT	1.00
/ Хоёр сая төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name Төрийн Сан		
	90			
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name		
	100061455403	До.Замын-Үүд БХНСэргээлт	2,000,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Монзоре эрдэс РД:4279077 2024 оны БОМТ барьцаа хөрөнгө

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)